

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.12.26

Д/д	Чиглэл	Д/д	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
1	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох.	1	Монгол Улсын Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан ажилтнуудын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөх	Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор баталсан цалингийн сүлжээг баримтлан 2025 онд нийт албан хаагчдад 170,272.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон бөгөөд тус албаны даргын 2024 оны А/01, А/10 дугаар тушаалаар цалин хөлсийг шинэчлэн тогтоосон болно.	100.0%
2		2	Төрийн албан хаагчдад олгох нэмэгдэл, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг баримтлан нэмэгдэл хөлсийг олгох	Холбогдох хууль, тогтоол шийдвэрийг үндэслэн 2025 онд нийт албан хаагчдад 132,121.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс, урамшуулал олгосон.	100.0%
3		3	Монгол Улсын Төрийн албаны тухай хуулинд заасан хөнгөлөлтийг үзүүлэх	Монгол Улсын Төрийн албаны тухай хуулинд заасан хөнгөлөлтийг тухай бүрд нь үзүүлж байна.	100.0%
4		4	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгох	Тус албаны албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, хууль тогтоомжид заасны дагуу 2025 оны байгууллагын батлагдсан төсвөөс нийт 30,529.3 мянган төгрөгийн урамшууллыг олгосон болно.	100.0%
5		5	Төрийн дээд одон медалиар шагнагдсан, өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчдад байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэтгэмжийг олгох	Тус албаны архив, бичиг хэргийн ажилтан, нярав С.Мөнхцэцэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдсан бөгөөд тус албаны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 300.0 мянган төгрөг, мөн тус байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ахмад настанд Хаврын тэргүүн сар шинийн баярыг тохиолдуулан 160.0 мянган төгрөг, албан хаагчдын хүүхдүүдэд “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан 706.7 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлж, байгууллагын 2025 оны батлагдсан төсвөөс нийт 1,166.7 мянган төгрөгийг зарцуулсан болно.	100.0%

6	Албан хаагчдын чиг тушаалын үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл боломжоор хангах	1	Албан хаагчдыг сүүлийн үеийн технологийн шаардлага хангахуйц компьютер, техник хэрэгслээр хангах	Албан хаагчдад зайлшгүй шаардлагатай нийт 20,611.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг тус албаны 2025 оны батлагдсан төсвөөс худалдан авч данс бүртгэлд тусгасан болно. Нийт албан хаагчид албан ажлын бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, сканнер, хувилагч болон бусад техник хэрэгслэлээр бүрэн хангагдсан болно.	100.0%
7		2	Албан хаагчид ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулахад тодорхой санал санаачлагатай ажиллах		100.0 %
8		3	Ажил үүргийн давхардал, ажлын хэт их ачааллыг оновчтой хуваарилах, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан хөлсийг тухай тооцож бүр олгох	Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцүүлэх, оновчтой хуваарилахад анхаарч ажиллаж байгаа бөгөөд ажлын ачаалал, батлагдсан орон тоо дутуу ажиллаж байгаагаас шалтгаан албан хаагчид илүү цагаар ажиллаж, албан хаагчдад холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу ажлын үр дүнг харгалзан илүү цагийн нэмэгдэл хөлсийг холбогдох хууль, журмын дагуу тухай бүр олгож ажиллалаа.	100.0 %
9	Амьдрах орчин нөхцлөө сайжруулахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх	1	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх	Тус албаны албан хаагчдаас гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагч байхгүй тул байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар түлшний үнийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлээгүй болно.	48.0 %
10		2	Албан хаагчдын амьдарч буй орчин нөхцөл, ажилласан жилийн судалгааг гаргаж, жилд 1 албан хаагчид амьдрах орчин нөхцлөө сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх	Албан хаагчдын амьдарч буй орчин нөхцөл, ажилласан жилийн судалгаанд үндэслэн архив, бичиг хэргийн ажилтан, нярав С.Мөнхцэцэгт амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлж 1,700.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.	100.0 %
11	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх	1	Төрийн албан хаагчдыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж шаардлагатай албан хаагчдад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад нь дэмжлэг үзүүлэх	Дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгийн багц шинжилгээнд бүрэн хамруулж, 2025 оны байгууллагын батлагдсан төсвөөс 1,650.0 мянган төгрөгийг зарцуулсан болно.	100.0 %
12		2	Рашаан сувилалд явж байгаа албан хаагчдад унааны зардлыг нийтийн тээврийн үнэ тарифаар	Тус албаны албан хаагчдаас 2025 онд холбогдох асуудлаар өргөдөл хүсэлт ирүүлээгүй байна.	48.0 %

		тооцон 2 жилд нэг удаа олгох		Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний хүрээнд тус албаны нийт албан хаагчид өдөр бүр 10-15 минут ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж байна. Мөн тус дүүргийн "Энхийн өргөө" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран тус албаны нийт албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, биеийн индекс оношилгооны аппаратаар иж бүрэн оношилж, албан хаагчдад эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.	100.0 %
13	3	Эрүүл мэндийн бие бялдарын түвшин тогтоох үзлэгт хамруулж чийрэгжүүлэх, бялдаржуулах арга хэмжээ, аялал зугаалга зохион байгуулах		2025 онд тус албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу холбогдох дээд шатны байгууллагуудаас болон тус албаны зүгээс бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан нийт 11 сургалтад давхардсан тоогоор нийт 73 албан хаагчдыг хамрууллаа. Мөн Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан Аудиторын эрх олгох сургалтад тус албаны 4 аудитторыг хамруулсан. Албан хаагчдыг мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж албаны 2025 оны батлагдсан төсвөөс 2,970.0 мянган төгрөгийг зарцуулсан.	100.0 %
14	1	Албаны 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу албан хаагчдыг сургалтад хамруулах		"Дотоод аудиторуудын мэдлэг хуваалцах сар"-ын хүрээнд Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас санаачлан Монгол Улсын Сангийн яамтай хамтран "Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй" сэдэвт салбарын туршлага солилцох, сургалт арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, тус үйл ажиллагаанд албаны дарга, нийт дотоод аудиторууд, мөн Монгол Улсын Сангийн яам, Азийн Хөгжлийн банк (АХБ)-тай хамтран "Улсын салбарын дотоод аудиторуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох зөвлөгөөн"-ийг 2025 оны 11 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтад тус албаны Ахлах дотоод аудитор Ш.Болормаа, Г.Энхзул нар танхимаар, бусад нь цахимаар хамрагдсан.	100.0 %
15	2	Аймаг, дүүргүүдийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, албадын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох			

16	3	Албан хаагчдыг гадаад сургалтад хамруулах талаар боломж нөхцөлийг судлах	Холбогдох мэргэжлийн болон салбарын сургалтыг судалж байна.	48.0%
	НИЙТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХУВИАР			90.2%

БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН:

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД

АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Д.ТӨМӨРБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР

Г.ЭНХЗУЛ

